



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/180/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор 2022 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.2 Төлбөрийн акт	16
4.3 Аудитын зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.08.25

№ 2/24

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Аймгийн Онцгой комиссоос олгосон 23,364.5 мянган төгрөгийг хүнсний материалын орлого, зарлагыг санхүүгийн тайланд тусгаж тайлагнаагүй байна.

- Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед байгууллагын төсвөөс нэмж 14,116.3 мянган төгрөгийг зарцуулахдаа Төсвийн захирагч шийдвэр гаргаагүй.

- Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т “Аж ахуйн бүх ажил, гүйлгээ”-г нягтлан бодох бүртгэлд тусгана гэсэн заалтууд Засгийн газрын 2021 оны 43 дугаар батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар арга хэмжээний тухай” тогтоол, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

d:\alban.bichig.a4-toot.docx

• 0050?0243

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

The image shows a handwritten signature in black ink over a red rectangular stamp. The stamp contains Mongolian text, including 'Аудитын байгууллага' (Audit Agency) and 'Төрийн аудит' (State Audit). The signature is written in a cursive style.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,331,969.00	53,942,763.00
35	БАРАА МАТЕРИАЛ	66,331,969.00	53,942,763.00
351	Түүхий эд материал	51,348,069.00	44,936,131.00
35110	Тусгай зориулалттай материал	50,339,569.00	43,553,131.00
35130	Эм боох материал	1,008,500.00	1,383,000.00
354	Хангамжийн материал	14,983,900.00	9,006,632.00
35410	Бичиг хэргийн материал	187,200.00	269,200.00
35420	Аж ахуйн материал	3,103,600.00	366,900.00
35450	Барилгын засварын материал	5,152,100.00	66,000.00
35460	Хүнсний материал	00.00	1,763,532.00
35470	Бусад хангамжийн материал	6,541,000.00	6,541,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	460,655,725.77	441,719,034.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	460,655,725.77	441,719,034.50
392	Биет хөрөнгө	435,538,392.61	416,719,034.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	457,121,172.00	457,121,172.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-57,794,268.32	-72,081,994.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,370,344.27	45,571,544.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,627,307.18	-31,247,591.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,997,360.62	37,023,691.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	-18,301,019.98	-22,299,898.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,200,000.00	2,200,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-513,333.38	-953,333.42
39217	Ном	1,085,444.58	1,385,444.58
393	Биет бус хөрөнгө	25,117,333.16	25,000,000.00
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-762,666.84	-880,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,000,000.00	25,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	526,987,694.77	495,661,797.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	302,537.07	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	302,537.07	00.00
413	Өглөг	302,537.07	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	302,537.07	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	526,685,157.70	495,661,797.50
51	Засгийн газрын хувь оролцоо	526,685,157.70	495,661,797.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,000,000.00	25,000,000.00
51101	Өмч: - төрийн	25,000,000.00	25,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	501,685,157.70	470,661,797.50
51210	Өмнөх үеийн үр дүн	501,685,157.70	501,685,157.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-31,023,360.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	526,987,694.77	495,661,797.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	357,935,800.00	434,251,667.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,388,500.00	7,866,162.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,388,500.00	7,866,162.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,388,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,388,500.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	00.00	2,275,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	00.00	5,591,162.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,547,300.00	426,385,505.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	318,110,800.00	314,622,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	318,110,800.00	314,622,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	82,262,160.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	55,995,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,266,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,436,500.00	29,500,445.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,436,500.00	29,500,445.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	354,093,661.43	464,147,632.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	354,093,661.43	464,147,632.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	351,345,149.95	434,303,709.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,984,529.21	225,607,823.95
210101	Үндсэн цалин	204,657,946.21	192,719,914.95
210102	Нэмэгдэл	11,488,383.00	16,464,888.00
210104	Урамшуулал	6,838,200.00	16,423,021.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,704,458.38	30,886,096.36
210201	Тэтгэврийн даатгал	19,612,601.07	20,996,318.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,338,205.00	2,226,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,951,445.00	1,633,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	678,505.31	593,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,123,702.00	5,436,077.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,336,400.00	29,000,445.00
210301	Гэрэл, цахилгаан	2,338,812.00	4,073,296.00
210302	Түлш, халаалт	24,229,274.00	22,668,818.00
210303	Цэвэр, бохир ус	2,768,314.00	2,258,331.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,256,500.00	37,100,200.00
210401	Бичиг хэрэг	33,800.00	185,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,389,600.00	1,376,400.00
210404	Ном, хэвлэл	18,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	492,800.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,722,300.00	19,214,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	13,824,400.00
2105	Нормативт зардал	31,245,100.00	48,623,088.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,203,100.00	5,975,000.00
210502	Хоол, хүнс	30,042,000.00	42,648,088.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,198,200.00	8,193,000.00
210604	Урсгал засвар	1,198,200.00	8,193,000.00
2107	Томилолт, зочны зардал	105,700.00	00.00

210702	Дотоод албан томилолт	105,700.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,513,200.00	26,825,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,213,200.00	26,825,660.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,001,062.36	28,067,396.58
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,060,400.00	1,435,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,940,662.36	26,632,296.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,748,511.48	29,843,922.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,000.00	26,361,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	26,266,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,000.00	94,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,482,622.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,482,622.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,635,511.48	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,635,511.48	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,842,138.57	-29,895,965.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,127,394.69
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,127,394.69
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,127,394.69
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,842,138.57	-31,023,360.20

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	352,547,300.00	426,385,505.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	352,547,300.00	426,385,505.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	318,110,800.00	314,622,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	82,262,160.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	55,995,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,266,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,436,500.00	29,500,445.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,436,500.00	29,500,445.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	352,547,300.00	419,837,505.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,547,300.00	419,837,505.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,798,788.52	389,993,582.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	222,963,846.52	226,554,357.38
210101	Үндсэн цалин	182,373,752.58	190,141,548.38
210102	Нэмэгдэл	24,266,783.94	19,613,477.00
210104	Урамшуулал	13,672,094.00	16,799,332.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,651,216.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,728,342.00	30,242,100.00
210201	Тэтгэврийн даатгал	19,716,642.00	21,334,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,003,000.00	2,226,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,602,300.00	1,781,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	400,600.00	445,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,005,800.00	4,453,600.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,336,400.00	29,000,445.00
210301	Гэрэл, цахилгаан	2,338,812.00	4,073,296.00
210302	Түлш, халаалт	24,229,274.00	22,668,818.00
210303	Цэвэр, бохир ус	2,768,314.00	2,258,331.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,349,100.00	19,314,700.00
210401	Бичиг хэрэг	102,000.00	185,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	2,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,389,600.00	1,376,400.00
210404	Ном, хэвлэл	56,500.00	347,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	876,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,325,000.00	14,905,500.00
2105	Нормативт зардал	43,282,500.00	19,343,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,052,700.00	5,144,300.00
210502	Хоол, хүнс	28,563,400.00	13,773,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,666,400.00	425,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,273,300.00	3,618,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	973,000.00
210604	Урсгал засвар	6,273,300.00	2,645,500.00
2107	Томилолт, зочны зардал	105,700.00	00.00
210702	Дотоод албан томилолт	105,700.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	856,000.00	57,660,860.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	556,000.00	57,070,860.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,903,600.00	4,259,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	3,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,903,600.00	759,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,748,511.48	29,843,922.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	113,000.00	26,361,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	26,266,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,000.00	94,900.00
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,482,622.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,482,622.62
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,635,511.48	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,635,511.48	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	6,548,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	6,548,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	6,548,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	6,548,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	6,548,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-6,548,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,000,000.00	497,843,019.13	522,843,019.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,000,000.00	497,843,019.13	522,843,019.13
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	3,842,138.57	3,842,138.57
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,000,000.00	501,685,157.70	526,685,157.70
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	25,000,000.00	501,685,157.70	526,685,157.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	25,000,000.00	501,685,157.70	526,685,157.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	-31,023,360.20	-31,023,360.20
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	25,000,000.00	470,661,797.50	495,661,797.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

мянган төгрөг

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	345,611,700.00	340,640,722.38	4,970,977.62	98.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,611,700.00	340,640,722.38	4,970,977.62	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	345,516,800.00	340,545,822.38	4,970,977.62	98.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,631,800.00	226,554,357.38	3,077,442.62	98.7
210101	Үндсэн цалин	192,928,700.00	190,141,548.38	2,787,151.62	98.6
210102	Нэмэгдэл	19,621,100.00	19,613,477.00	7,623.00	100.0
210104	Урамшуулал	17,082,000.00	16,799,332.00	282,668.00	98.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,392,100.00	30,242,100.00	150,000.00	99.5
210201	Тэтгэврийн даатгал	21,484,800.00	21,334,800.00	150,000.00	99.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,226,800.00	2,226,800.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,781,500.00	1,781,500.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	445,400.00	445,400.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,453,600.00	4,453,600.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,488,800.00	29,000,445.00	1,488,355.00	95.1
210301	Гэрэл, цахилгаан	4,550,000.00	4,073,296.00	476,704.00	89.5

210302	Түлш, халаалт	22,678,800.00	22,668,818.00	9,982.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	3,260,000.00	2,258,331.00	1,001,669.00	69.3
2104	Хангамж, бараа материалын зардал	19,614,700.00	19,614,700.00	0.00	100.0
210401	Бичиг хэрэг	185,400.00	185,400.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,376,400.00	1,376,400.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	647,400.00	647,400.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	500,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,905,500.00	14,905,500.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	19,510,200.00	19,343,620.00	166,580.00	99.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,144,300.00	5,144,300.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	13,940,500.00	13,773,920.00	166,580.00	98.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	425,400.00	425,400.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,866,500.00	9,866,500.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,221,000.00	7,221,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,645,500.00	2,645,500.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	88,600.00	00.00	88,600.00	0.0
210702	Дотоод албан томилолт	88,600.00	00.00	88,600.00	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,665,100.00	1,665,100.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,075,100.00	1,075,100.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4259000.00	4259000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	759,000.00	759,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94900.00	94900.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,900.00	94,900.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	94,900.00	94,900.00	0.00	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	345,611,700.00	340,640,722.38	4,970,977.62	98.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	314,622,900.00	311,140,277.38	3,482,622.62	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	314,622,900.00	311,140,277.38	3,482,622.62	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,988,800.00	29,500,445.00	1,488,355.00	84.0
132001	Орон нутгийн төсвөөс	30,988,800.00	29,500,445.00	1,488,355.00	84.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	126	126	0.00	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	126	126	0.00	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	126	126	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	82,262,160.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	82,262,160.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	55,995,760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	55,995,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	55,995,760.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	26,266,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	26,266,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.00	26,266,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	82,262,160.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	82,262,160.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	55,995,760.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	26,266,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 25 өдрийн 03 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ц.Оюунчимэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Одончимэг нар зурж байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэг нь зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багш нар цэцэрлэгийн үзэл баримтлалдаа уялдуулан сургалтын хөтөлбөрөө боловсруулан, сургалтын явцад бэлтгэл бүлэг "Ном", "Навч" ахлах бүлэг "Шаазгай", дунд бүлэг "Туулай", бага бүлэг хүүхдийн чадварт суурилсан тоглоомын аргачлал боловсруулан сургалтыг явуулж сэдэвтэй уялдуулан хүүхдүүд өөрсдийн хийсэн бүтээлээрээ анги танхимын орчноо бүрдүүлж сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны эхний 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 354,093.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,311.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 3,186.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 4,177.3 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31,325.9 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,332.0	53,942.8	(12,389.2)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	66,332.0	53,942.8	(12,389.2)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	460,655.7	441,719.0	(18,936.7)
Үндсэн хөрөнгө	565,654.3	569,181.9	3,527.5
Хуримтлагдсан элэгдэл	(104,998.6)	(127,462.8)	(22,464.2)
Нийт хөрөнгө	526,987.7	495,661.8	(31,325.9)
Өр төлбөр	302.5	-	(302.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	526,685.2	495,661.8	(31,023.4)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	526,987.7	495,661.8	(31,325.9)

Эх сурвалж: Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 53,942.8 мянган төгрөг болж 12,389.2 мянган төгрөгөөр буурсан нь цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.12.28-ны 62 дугаар тушаалаар тусгай зориулалтын материалаас 13,824.4 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, аж ахуйн материал 2,736.7 мянга, барилгын засвар материал 5,086.1 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 569,181.9 мянган төгрөг болж 3,527.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,548.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 2,275.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021.12.28-ны өдрийн 56 тогтоолоор 5,295.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Ажиллагсадтай холбоотой өглөгийн данс 302.5 мянган төгрөгийн НДШ-ийн өглөг байсан бөгөөд тайлант хугацаанд барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 495,661.8 мянган төгрөг болж 31,023.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 31,023.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 484,438.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 484,438.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 132,978.9 мянган төгрөгөөр бууруулж 351,459.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 340,640.7 мянган төгрөг болгож 10,818.7 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 345,611.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 314,622.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 30,988.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 314,622.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 29,500.4 санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 340,640.7 мянган төгрөгийг зарцуулж 3,482.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 340,640.7 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 3,077.4 мянга, ажил олгогчоос төлөх НДШ-ээс 150.0 мянга, хоолны зардлаас 166.6 мянга, дотоод албан томилолтын зардлаас 88.6 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 55,995.8 мянган төгрөгийг Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд тусгаарлан хэвтэх, эмчлүүлэх байранд эмчлүүлсэн иргэд болон ажилтан албан хаагчдын хоолны зардал, дээд шатны төсвийн захирагчаас 26,266.4 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж нийт 6 сартай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Б.Азбаяр аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 8 зорилтын хүрээнд 31 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 464,17.6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 110,053.9 мянган төгрөгөөр буюу 31.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж тус тус нэмэгдсэн, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, томилолт зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

Монгол улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сумын Онцгой комиссын шийдвэрээр Өлзийт сумын пост, Эрдэнэцогтын гарам, Герман толгойн пост, Дунд булгийн пост, 10 мянгатын постод гарч ажилласан төрийн албан хаагчид болон Нэгдэлчин, Жаргалант, Баянбулаг, Баянхонгор, Энхнамуун, Соёмбо зочид буудлын тусгаарлан ажиглах эмчлүүлэх байр, Жаргалтай амьдрал төв, Эрдэнэмандал сургуулийн эмнэлгийн төрийн албан хаагчид болон тусгаарлагдсан болон эмчлүүлсэн иргэдэд өдөр 3 удаагийн халуун хоол цайгаар үйлчилсэн байна.

Дээрх хоолыг бэлтгэхэд 23,364.5 мянган төгрөгийн хүнсний материалыгсард аймгийн Онцгой байдлын газраас олгосон ба тухайн байгууллага нь санхүүгийн тайланд орлог, зарцуулалтыг тусгаагүй анхан шатны баримт байхгүй байна.

Мөн аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 52904.1 мянган төгрөгийгсард байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна.

Тухайн байгууллага нь дээрх мөнгөнөөс гадна байгууллагын төсвөөс 3,101.9 мянга нийт 56,006.0 мянган төгрөгөөр хүнсний материал авч хоол бэлтгэн, нийт 3507 хүн өдөр хамрагдаж, дунджаар өдөрт 14543-20627 төгрөгийн өртгөөр хоолыг бэлтгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 536,841.7 мянган төгрөгийн 151 мэдээллийг 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан ба дахин орж зассанаас 4 мэдээлэл хугацаа хоцорсон төлөвтэй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	92	4	
	Нийт	27	151	145	4	2

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд нийт 345,611.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 340,640.7 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст тусгай зориулалтын шилжүүлгээс 3,482.6 мянган төгрөг буюу төсвийн 1.1 хувийг буцаан төвлөрүүлсэн, орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр санхүүжиж 1,488.3 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 35,636.5 мянган төгрөгөөр, тодотголоор 5,147.7 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 29,000.4 мянган зарцуулж анх баталсан дүнгээс 6,636.1 мянган төгрөг буюу 18.6 хувь хэмнэсэн ч Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зорим арга хэмжээний тухай" тогтоолын 1.8 дахь заалтаар 20 -оос доошгүй хувийг хэмнэх гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй ба түлш халаалтын зардлаас 2,686.6 мянга зориулалт урсгал засварын зардалд зарцуулсан байна.

Мөн Төрийн аудитын байгууллагаас хийсэн "Төсөвт байгууллагын халаалтын зардлын төлөвлөл гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгсний дагуу аймгийн Мэргэжлийн хяналт хэмжилт хийж 2021.09.15-аас 163.7 м2 бууруулж 928.2 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Ковид-19 цар тахалтай холбоотой постны хоолны зардалд хүүхдийн хоолны зардлаас 3,101.9 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас нэг удаагийн аяга, таваг, халбага, хүнсний скоч, тор худалдан авахад 11,014.4 мянган төгрөгийг дээд шатны болон байгууллагын даргын тушаал шийдвэр гаргалгүйгээр төсвөөс зарцуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,966.2 мянган төгрөгийн 3 төрлийн зөрчил илэрснээс 2,709.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өгч 12,257.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан постод ажиллаж байгаа төрийн албан хаагчид, тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан иргэд, эмнэлгийн ажиллагсдын хоолны зардлыг тус байгууллагын батлагдсан хүүхдийн хоолны зардлаас 3,101.9 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 11,014.4 мянган төгрөгийн нэг удаагийн аяга, таваг, халбага, хүнсний скоч, тор худалдан авахад дээд шатны болон байгууллагын даргын тушаал шийдвэр гаргалгүй зарцуулсан байна.

Дээрх зардлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 43,386.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 2,686.6 мянган 1 төлбөрийн акт, алдаа зөрчил давтан гаргахгүй байх 37,598.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

4.2 Төлбөрийн акт

1. Түлш халаалтын зардлаас тухайн байгууллагад дулаан нийлүүлдэг "Чандмань-Баянхонгор" ХК-д 2021.06.22-нд хүнсний агуулахын дулаан холбох засварын зардалд 2,686.6 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021.10.29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын "Түлш халаалт"-ын зардлын ангиллыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түлш халаалтын зардлаас зориулалт бусаар зарцуулсан 2,686.6 мянган төгрөгийн халаалт нийлүүлэгч байгууллагаас суутган тооцоо хийж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Аудитын зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Монгол улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед тухайн цэцэрлэгээс постны хоолны зардалд хүүхдийн хоолны зардлаас 3,101.9 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас нэг удаагийн аяга, таваг, халбага, хүнсний скоч, тор худалдан авахад 11,014.4 мянган төгрөг зарцуулсан, мөн постны хоол хийх шийдвэр гарсны дагуу аймгийн Онцгой байдлын газраас мөнгийг шилжүүлж 23,364.5 мянган төгрөгийн хүнсний материал авч хоол хийж пост болон тусгаарлах байранд хоол өгсөн бөгөөд тус хүнсний материалыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-т “Аж ахуйн бүх ажил, гүйлгээ”-г нягтлан бодох бүртгэлд тусгана гэсэн заалтууд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах.

2. Цалингийн цэстээс түүвэр хийж үзэхэд 228,827.0 мянган төгрөгийг зардал гарсан байхад санхүүгийн үр дүнгийн тайлангаар 225,607.8 мянган төгрөгөөр тайлагнаж 3,219.2 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” , Сангийн сайдын 2021.10.29-ны өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд “Ажиллагчдын цалин, хөлс болон хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд энэ ангилалд хамрагдана” гэсэн заалтууд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин, НДШ-ийн нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ Сангийн сайдын 388 тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын ажиллагсадтай холбогдсон зардлын бүртгэл, нийгмийн даатгалын шимтгэлийн бүртгэлийг дагаж мөрдөх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын дугаар цэцэрлэг 13	3	43,386.6	0	0	1	2,686.6	0	0	2	40,700.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____